



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Коронавируст халдвар /Ковид-19/-ын
"Омикрон" хувилбарын тархалтаас
урьдчилан сэргийлэх зарим
арга хэмжээний тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.1, 27¹.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 65 дугаар хуралдаанаас Улсын онцгой комисст өгсөн чиглэл, Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн саналыг тус тус үндэслэн Улсын онцгой комиссоос ТОГТООХ нь:

1. Коронавируст халдварыг үүсгэгч SARS-CoV-2 вирусийн "Омикрон" хувилбарын тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн гадаад улсаас ирж байгаа бүх хүнээс хилийн нэвтрэх цэг, нисэх буудалд SARS-CoV-2 вирусийн антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээ, бх-ПГУ шинжилгээний сорьц авч, тусгаарлан ажиглах байранд 3 хоног тусгаарлах, тусгаарлан ажиглах байранд байх хугацаанд нь давтан бх-ПГУ шинжилгээ авах ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд, Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Билэгтсайхан болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

2. Тусгаарлан ажиглах байранд халдвар тархахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд, Улсын онцгой комиссын Нэгдсэн шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр, ХӨСҮТ-ийн захирал Ц.Билэгтсайхан, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал Н.Цогбадрах нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр нарт үүрэг болгосугай.

ДАРГА

С.АМАРСАЙХАН